

Баян-Агт сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Баг, сангуудын 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийсэн тухай

Нэг. Нийтлэг үндэслэл

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.10 дахь “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, 69 дүгээр зүйлийн 69.3 дахь “Дотоод аудитад төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээний төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмч давамгайлсан хуулийн этгээдийн санхүүгийн үйл ажиллагааг хамаарна” гэсэн заалт, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан “Дотоод аудитын дүрэм”-д заасан бүрэн эрхийн хүрээнд хяналт шалгалтыг явууллаа.

Хоёр. Шалгалтын зорилго

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөө, даргын баталсан 20 тоот удирдамжийн дагуу хөрөнгийн бүрдүүлэлт, зарцуулалт, хэрэгжилтийн байдал хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд хяналт шалгалтыг хийж санхүүгийн үйл ажиллагаанд нь үнэлэлт дүгнэлт өгч, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах, санал, зөвлөмж боловсруулан хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулж, мэргэжлийн туслалцаа үзүүлэхэд чиглэгдэв

Гурав. Шалгалтын хамрах хүрээ, бүрэлдэхүүн, хугацаа

Засаг даргын тамгын газар, Баг, Орон нутгийн хөгжлийн сан /ОНХС/Сум хөгжүүлэх сан, Байгаль хамгаалах сан, Баян агт сангийн 2016 оны санхүүгийн үйл ажиллагаанд Сангийн сайдын 2016 оны 107 тоот тушаалаар батлагдсан Санхүүгийн хяналт шалгалтын стандартын дагуу холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, лавлагаа тайлбар авах, судалгаа, тайлан мэдээг гаргуулан нэгтгэж шинжлэх, давтан тооцоолол хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, ажлын төлөвлөгөө, тайлантай тулган баталгаажуулах зэрэг ажлуудыг Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Д.Сарангэрэл 2017 оны 11 дүгээр сарын 06-аас 12-ныг дуустал хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Дөрөв. Шалгалтад хамрагдсан объектын талаар

ИТХ нь 8 ажиллагсадтай дарга нарийн бичгийн дарга, 6 багийн ИНХ-ын дарга,ЗДТГ нь үндсэн 17, гэрээт 5 нийт 22 орон тоотойгоор, Баг 6 багийн 6 даргын орон тоотойгоор ажилласан байна.

Шалгалтад хамрагдсан хугацааны ЗДТГ-ын гарын үсгийн нэгдүгээрийг дарга Г.Ганбат, Д.Нармандах гарын үсгийн хоёрдугаарыг нягтлан бодогч Г.Оюунтуяа, Б.Отгонцэцэг, ИТХ-ын нэгдүгээрийг дарга С.Ганболд, нарийн бичгийн дарга Б.Оюун эрдэнэ, гарын үсгийн хоёрдугаарыг нягтлан бодогч Г.Оюунтуяа, Б.Отгонцэцэг нар зурж хөрөнгө мөнгийг захиран зарцуулж, эд хариуцагчаар Д.Ганзориг, Б.Батцэцэг нар ажиллаж ирсэн байна.

Орон нутгийн хөгжлийн сан, СХСан, БХСан, ЖДҮДСан зэрэг тусгай зориулалтын сангуудыг шалгалаа. 1-р гарын үсгийг засаг дарга, 2-р гарын үсгийг Санхүүгийн албаны дарга нар зурж гүйлгээг хийсэн байна.

Баян-агт хөгжил сан, ГХС-д сумын Засаг даргын нэр дээр арилжааны банкинд харилцах данстай байна./Төрийн банкинд/

Тав. Шалгалтад хамрагдсан асуудлууд:

Хяналт шалгалтын удирдамжид заасан дараах асуудлуудыг бүрэн хамруулав
Үүнд: 2016 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ албан томилолтын бодолт, тооцоололт, цалин хөлсний бодолт, тогтоолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг авто машины замын хуудастай тулгаж, шатахууны хэтрэлт хэмнэлт, орлогын бүрдүүлэлт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, шилэн дансны тухай хэрэгжилтийг тооцон, байгууллагын дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нарт мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

5.1 Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар.

ИТХ: Тус байгууллага нь 2016 онд орон нутгийн 42925.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 37677.6 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 2327.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 2920.0 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 192.3 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

ЗДТГ: Тус байгууллага нь 2016 онд орон нутгийн төсвөөс 192910.1 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоор 1206.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 5987.2 мянган төгрөг, НДС-аас 2236.4 мянган төгрөг нийт 202948.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 158418.4 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 43167.8 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 207.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Баг: Тус байгууллага нь 2016 онд орон нутгийн төсвөөс 58959.5 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлэн ажиллаж төсвийн гүйцэтгэлээр ажиллагсадтай холбоотой зардалд 55982.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардалд 2976.6 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

5.2 Үндсэн хөрөнгө бараа материалын өөрчлөлт.

ИТХ: 2016 онд 12552.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг /машин тоног төхөөрөмж 8924.2 мянган төгрөг, тавилга эд хогшил 3554.3 мянган төгрөг, номын фонд 74.0 мянган төгрөг/ бүртгэлд тусгасан байсан бөгөөд шалгалтанд хамрагдсан тайлант онд хөрөнгө нэмэгдэж хасагдаагүй данс бүртгэлд тусгажээ

2016 оны эхэнд 123.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 459.0 мянган төгрөгийн аж ахуйн материалтай байсан ба тайлант хугацаанд 206.4 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1085.0 мянган төгрөгийн түлш, шатахуун орлогод авч, 148.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1085.0 мянган төгрөгийн түлш, шатахуун зарцуулан оны эцэст 180.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 459.0 мянган төгрөгийн аж ахуйн материалын үлдэгдэлтэй тайлагнасан байна

ЗДТГ: 2016 оны эхэнд 1206402.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөтэй байсан 37885.0 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна. Үүнээс , БХС-аар 19665.0 мянган төгрөгийн цэцэрлэгт хүрээлэн, 2270.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, ОНХС-аар

15950.0 мянган төгрөгийн сумын төвийн камержуулалт, шилжүүлэн авсан ба оны эцэст нийт 1952370.4 мянган төгрөгийн хөрөнгөтэйгээр данс бүртгэлд тусгажээ.

2016 оны эхэнд бараа материал 62448.7 мянган төгрөг байсан ба 30452.4 мянган төгрөгийн бараа материал нэмэгдсэн 756.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1600.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 10937.4 мянган төгрөгийн түлш шатахуун, 1904.0 мянган төгрөгийн аж ахуйн материал төсвийн хөрөнгөөр худалдан авсан ба БХС-аас 1120.0 мянган төгрөгийн дугуй шилжүүлэн авч, 721.0 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1626.1 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1600.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 9845.6 мянган төгрөгийн түлш шатах тослох материалыг тус тус зарцуулж, 732.9 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 10322.0 мянган төгрөгийн аж ахуйн материал, 1120.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 2341.8 мянган төгрөгийн түлш шатах тослох материал, 708.7 мянган төгрөгийн хангамжийн материал, 37370.0 мянган төгрөгийн малыг тус тус данс бүртгэлд үлдэгдлээр тусгасан байна.

Баг: 2016 оны эхэнд 315079.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгасан бөгөөд шалгалтанд хамрагдсан хугацаанд үндсэн хөрөнгө нэмэгдэж, хасагдаагүй байна.

2016 онд 103.2 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 1279.3 мянган төгрөгийн түлш, шатахуун орлогод авч, бүрэн зарцуулсан байна

5.3: Авлага, өглөг:

ИТХ: 2016 оны эхэнд өглөг 1420.0 мянган төгрөг байснаас 41505.0 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж, 42925.0 мянган төгрөгийн өглөг хасагдаж өглөггүй, авлагагүй тайлан баланс гарсан байна

ЗДТГ: 2016 оны эхэнд 4477.5 мянган төгрөгийн өглөгийн /633200 төгрөгийн ХХОАТ, 791323.50 төгрөгийн НДШ, 398000 төгрөгийн томилот, 100000 төгрөгийн залуучуудын шинэ жил/ үлдэгдэлтэй байсан ба 189288.4 мянган төгрөгийн өглөг нэмэгдэж, 193765.9 мянган төгрөгийн өглөг хасагдаж өглөггүй, 4051.4 мянган төгрөгийн авлага нэмэгдэж, хасагдан авлагагүй тайлан гарсан байна

Баг: 2016 оны эхэнд 208524.30 төгрөгийн өглөгтэй /158524.30 төгрөгийн НДШ, 50000 төгрөгийн ХХОАТ/ байснаас 58800.9 мянган төгрөгөөр нэмэгдэж, 58959.5 мянган төгрөгөөр хасагдаж, 50.0 мянган төгрөгийн /ХХОАТ/ өглөгтэй, авлагагүй тайлан баланс гаргасан байна.

5.4: Засаг даргын нөөц сангийн зарцуулалт:

Он	төлөвлөгөө	гүйцэтгэл	хувь
2016	10000.0	5468.8	55.0

5.5 Нэмэлт санхүүжилтийн дансаар:

ЗДТГ: 2016 онд 5957.7 мянган төгрөгийн эх үүсвэр бүрдүүлсэн байна. Аймгийн ЗДТГ-аас 45.0 мянган төгрөгийг шагнал, 500.0 мянган төгрөг хог хаягдал цэвэрлэх, УБХ-ээс 814218 төгрөг мал тооллого, НҮБ-аас 1304550 төгрөгийг иргэдэд материал

тараахад зарцуулсан шатахуун, ОБХ-ээс зам засварт 1717.9 мянган төгрөг мал эмч нарт томилолтонд 276.0 мянган төгрөг зарцуулсан байна.

5.6 Шилэн дансны хуулийн хэрэгжилт:

Төсвийн ерөнхийлөн захирагч: Төсөв гүйцэтгэл цэсний 60 мэдээлэл мэдээлэхээс 7 мэдээлэл хоцроосон, тендэр худалдан авалт цэсний 22 мэдээлэл мэдээлэхээс 4 мэдээлэл хоцроосон, бусад цэсний 31 мэдээлэл мэдээлэхээс 4 мэдээлэл хоцроосон,

Иргэдийн төлөөлөгчдийн хурал: Төсөв гүйцэтгэл цэсний 38 мэдээлэл мэдээлэхээс 1 мэдээлэл хоцроосон, тендэр худалдан авалт цэсний 31 мэдээлэл мэдээлэхээс 1 мэдээлэл хоцроосон, бусад цэсний 50 мэдээлэл мэдээлсэн,

Засаг даргын Тамгын газар: Төсөв гүйцэтгэл цэсний 38 мэдээлэл мэдээлэхээс 2 мэдээлэл хоцроосон, тендэр худалдан авалт цэсний 31 мэдээлэл мэдээлэхээс 1 мэдээлэл хоцроосон, бусад цэсний 50 мэдээлэл бүрэн мэдээлсэн байна.

5.7 Орон нутгийн хөгжлийн сан

Сумын ИТХ-ын хуралдааны 2015 оны 12 дугаар сарын 19-ний 07/03 дугаар тогтоолоор 19 төсөл, арга хэмжээнд 149744.5 мянган төгрөгийг зарцуулахаар баталсан тодотголоор 18 төсөл арга хэмжээ батлагдаж, гүйцэтгэлээр 16 төсөл арга хэмжээ хэрэгжиж 123904.0 төгрөгийг зарцуулсан байна. Бэлчээрийн худаг засварлах, булаг шанд хаших 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна. 16 төсөл арга хэмжээнээс 1 төслийг нээлттэй тендэр шалгаруулалтаар, 4 төслийг харьцуулалтын аргаар, 7 төслийг шууд гэрээ байгуулж, 5 төсөл арга хэмжээ нь худалдан авах ажиллагаа зохион байгуулахгүй ажлууд байна.

Эх үүсвэр		Сумын ИТХ-аар баталсан		Тодотголоор	Гүйцэтгэлээр	харилцах үлдэгдэл
2015 оны зарцуулагдаагүй үлдэгдэл	8046840.00	төсөл арга хэмжээний тоо	19	18	16	11925623.46
аймгаас	127282800					
бусад эх үүсвэрээс	500000	Мөнгөн дүн	149744500	126387300	123904016.5	
нийт эх үүсвэр	135,829,640					

ОНХС-аар хийгдсэн ажлын гүйцэтгэл:

№	Төсөл арга хэмжээний нэр	Санхүүжилт / гэрээ /	Гүйцэтгэл	Гүйцэтгэсэн байгууллага
1	<i>Соёлын төвд тоног төхөөрөмж авах</i>	13000000	13000000	Онъ тэнгэрийн бичиг ХХК УБ хот
2	<i>Сумын төвд камержуулалт хийх</i>	15950000	15950000	Хөх хас ХХК Орхон аймаг
3	<i>ЭМТөвд мороги барих</i>	14696800	14696800	Энэрэл ОНОБүл

4	159 хүүхдийн хичээлийн байрны төмөр дээрийг засварлах	1500000	1500000	бүтээлч онобул
5	халуун ус, сауныг засварлах	2493000	2493000	Бэсүүд ОНОБүл
6	Сургуульд нэг анги тохижуулах	3500000	3500000	ЭРДЭМ ОНОБҮЛ Х.ЭНХЖАРГАЛ
7	багуудыг тохижуулах	5571400	5571400	сүлд онобул д.ганзориг
8	Гудамж зам, талбайг засварлах, арчилгаа, цэрлэгээ хийж, хог бохир зөөвөрлөх / хогны машин, муу усны машин, индүүны машин ажлуулах/	7500000	7266363.74	Г.Ган-Эрдэнэ ОНОБүл
9	Олон нийтийн цагдаа ажлуулаж, нийтийн эзэмшлийн өмч хөрөнгийг хамгаалах /	5800000	4783852.80	Б.Энхболд ОНЦагдаа
10	Усан хангамж ариутгал, татуурга, цэвэрлэх байгууламж, дулааны шугам/ зураг төсөл /	40000000	35000000	Гэрэгэ дизайн ХХК УБ хот
11	Цэцэрлэгт зөөлөн эдлэл авах	2000000	2000000	сөб онобул
12	Үндэсний их баяр наадам	10000000	10000000	здтгазар
13	Бестагро ХХК бага оёрын өвс преслэгчийн гэрээний үлэгдэл	3969400	3895000	Бестагро ХХК
14	Баянөндөрбулаг ХХК заалны шал засвар гэрээгээр	2825000	2824000	Баян-Өндөрбулаг ХХК УБ хот
15	Бичиг хэрэ / ТББ-ний орлогоос /	1000000	651000	здтгазар
16	Сургуулийн дуу хөгжмийн тоног төхөөрөмж	772600	772600	Бүтээлч ОНОБүлл
НИЙТ ДҮН		130578200	123904016.54	

5.8 БАЯН-АГТ СУМЫН БАГИЙН ЗЭЭЛ ОЛГОЛТ ҮЛДЭГДЛИЙН БАЙДАЛ /ЖДҮД сан/

№	д/д	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	Анх авсан зээлийн		2017.01.01 үлд	төлөх			төлсөн	зээлийн үлдэгдэл 2017.10.30
			Он, сар, өдөр	Мөнгөн дүн		2017 он олгосон	бодогдсон хүү	нийл төлөх		
1	1	С.Ариунболд	2012.05.08	300000	339128	0	0	0	92000	247128
2	2	Д.бямбасүрэн	2012.11.13	500000	352000		0	0		352000
3	3	А.Оюунэрдэнэ	2012.11.05	500000	178963		0	0		178963
		2012 оны дүн		1300000	870090	0	0	0	92000	778090
4	1	И.дагва	2013.10.15	500000	3700		100	100	3800	0
		2013 оны дүн		500000	3700	0	100	100	3800	0
5	1	П.Болдсайхан	2014.05.13	500000	515		0	0		515
6	2	Ш.Гансүх	2014.05.19	460000	480000		0	0		480000
7	3	Д.Цогтгэрэл	2014.06.09	700000	731815		0	0		731815
8	4	гомбосүрэн	2014.07.01	1000000	53888		0	0		53888
9	5	сэмжидбаатар	2014.07.31	960000	4800		0	0		4800
10	6	түвшинтогтох ганчимэг	2014.12.20	500000	515000		0	0		515000
11	7	МЯГМАРСҮРЭН	2014.07.31	1000000	460000		0	0		460000
12	8	ямпилсүрэн	2014.12.20	860000	396600		0	0		396600
13	9	7 Мөнгөнбагана	2014.12.25	500000	515000		0	0		515000
		2014 он дүн		6480000	3157618	0	0	0	0	3157618
14	10	д.отгонсүрэн	5	500000	507500		10500	10500	518000	0
15	11	н.тунсаг	5	470000	260000		0	0		260000
16	12	Гямц	2015.10.12	1000000	995500		27500	27500	1023000	0
		2015 оны дүн		1970000	1763000	0	38000	38000	1541000	260000
17	13	Дождцэгмэд	2016.05.11	500000	507500		7500	7500	515000	0
18	14	Соёлэрдэнэ	2016.05.11	1000000	1007500		22500	22500	1030000	0
19	15	Ж.Баянжаргал	2016.05.11	500000	515000		0	0	515000	0
20	16	Э.Баасансүрэн	2016.05.16	1000000	1015000		15000	15000	1030000	0
21	17	б.даваадорж	2016.05.24	500000	500000		7500	7500	507500	0

22	18	чинбат	2016.05.26	1000000	993580		18500	18500	1012080	0
23	19	ч.бямбажав	2016.08.15	500000	505000		10000	10000	515000	0
24	20	т.бадрал	2016.08.16	1000000	1011250		17500	17500	250000	778750
25	21	д.нарантуяа	2016.09.13	400000	403600		10000	10000		413600
26	22	д.батжаргал	2016.09.15	1000000	1009000		25000	25000		1034000
27	23	Ц.Баянжаргал	2016.09.21	1000000	1009000		25000	25000		1034000
28	24	ц.ганболд	2016.11.23	1000000	1003750		25000	25000		1028750
		2016 оны дүн		9400000	9480180	0	183500	183500	5374580	4289100
		НИЙТ ДҮН		19650000	15274588	0	221600	221600	7011380	8484808
29	1	с.даваасүрэн	2017.02.01	1000000		1000000	22500	1022500		1022500
30	2	ж.дэнсээхүү	2017.02.08	1000000		1000000	22500	1022500		1022500
31	3	лхамноров	2017.02.10	200000		200000	4500	204500		204500
32	4	батжаргал	2017.02.21	500000		500000	7500	507500	507500	0
33	5	гантөмөр	2017.05.26	1000000		1000000	12500	1012500	2500	1010000
34	6	золбоохүү	2017.05.29	1000000		1000000	12500	1012500		1012500
35	7	төрмандах	2017.05.30	500000		500000	11250	511250		511250
36	8	цэцгээ	2017.05.30	1000000		1000000	22500	1022500		1022500
37	9	Соёлэрдэнэ	2017.05.30	1000000		1000000	22500	1022500		1022500
38	10	д.дашцэрэн	2017.06.08	1000000		1000000	22500	1022500		1022500
39	11	ц.баярсайхан	2017.07.27	1000000		1000000	7500	1007500		1007500
40	12	Ч.Жамсранжав	2017.08.16	1000000		1000000	5000	1005000		1005000
		2017 он дүн		10200000		10200000	173250	10373250	510000	9863250
		НИЙТ ДҮН		29850000	15274588	10200000	394850	10594850	7521380	18348058

5.9 Сум хөгжүүлэх сан:

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 134 дүгээр тогтоолоор Сум хөгжүүлэх сан байгуулагдаж улсын төсвөөс суманд үйл ажиллагаа явуулж буй жижиг, дунд үйлдвэр эрхлэгчийг дэмжих, тэдэнд бага хүүтэй банкны шаардлагаас гадуур зээл олгох, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор дараах байдалтайгаар олгосон байна.

МД	Төслийн нэр, үйл ажиллагааны чиглэл	Төсөл хэрэгжүүлэгчийн нэр	Анх авсан зээлийн		2017.10.31 үлдэгдэл
			Он, сар, өдөр	Мөнгөн дүн	
1	2	3	4	5	6
1	блок үйлдвэрлэл	М.Даваабаатар	2011.07.07	15000000	
2	Эсгий эсгий эдлэл	Г.Пэрлэймаа	2011.07.17	13000000	13704013.86
3	Оёдол	Б.Батцэцэг	2011.07.15	2500000	0
4	Гурил арвайн гурил	М.Ерөөлт	2011.07.16	7000000	0
5	гутал	Г.Ганцоож	2011.07.16	3000000	10522.98
6	Оёдол	П.ОтгонЭрдэнэ	2011.07.16	2000000	0
7	зурагчин	Г.Мөнхбаатар	2011.08.02	2500000	0
8	гахай	Д.Чулуунбат	2011.07.16	5000000	5425083.73
9	талх нарийн боов	Г.Оюун-Эрдэнэ	2011.07.16	2000000	0
10	гэр ахуйн модон эдлэл	Г.Цогнэмэх	2011.08.17	1740000	65971.42
11	гахай	Л.Намсрай	2011.07.16	1000000	0
12	цайны газар	П.Батцэнгэл	2011.07.16	1000000	0
13	гэрийн мод	Б.Буянтотгох	2011.09.12	1300000	0
14	тодон эдлэл	Д.Уугандаваа	2011.07.16	1000000	0
15	цайны газар	У.Золбоохүү	2011.09.03	1000000	0
	ДҮН	2011 оны дүн		59040000	19205592.17
16	эсгий эдлэл	Т.Батбаяр	2012.02.10	1000000	0
17	гахай	Ц.Ганбаатар	2012.02.10	1000000	0
18	тахяны аа	Н.Ням-Очир	2012.03.12	1800000	0
19	тахяны аа	Л.Ядамжав	2012.08.30	1000000	0
20	гахай	Ц.Ган-Очир	2012.08.30	3000000	0
21	хурган дээл	Д.Цогт-Очир	2012.08.30	2000000	0
22	талх нарийн боов	Г.Оюун-Эрдэнэ	2012.11.05	3400000	305988.86
23	цайны газар	Ш.Энхжаргал	2012.11.05	1000000	0

24	хадлан бэлтгэх	Э.Энхбаяр	2012.08.20	1000000	0
25	дээл хийх	Б.Сарантуяа	2012.11.30	500000	0
		2012 огы дүн		15700000	305988.86
25	цайны газар	М.Лхагвасүрэн	2013.01.16	500000	0
26	цайны газар	Я.Шинэбаяр	2013.01.16	1000000	304.9
27	цайны газар	Д.Ганзориг	2013.01.16	500000	0
28	цайны газар	П.Дуламсүрэн	2013.01.17	500000	0
29	хурган дээл	Д.Рэнцэнханд	2013.01.18	1200000	0
30	Мал	Ш.Ганбаатар	2013.01.18	500000	0
31	блок үйлдвэрлэл	М.Даваабаатар	2013.04.11	8000000	-0.23
32	нөхөн сэргээх эмчилгээ	А.Эрдэнэчимэг	2013.04.11	10000000	10132949.54
33	Хар ямаа	Д.Мөнх-Эрдэнэ	2013.04.11	6500000	16335.68
34	хотонт хонь	Н.Гантулга	2013.04.11	5500000	5552.35
35	гагнуур	Б.Доржнямбуу	2013.04.11	1800000	0
36	худаг засвар	Р.Батсайхан	2013.04.11	3000000	633242.7575
37	төмс хүнсний ногоо	Т.Батбаяр	2013.04.11	3000000	0.04
38	Тэжээлийн ургамал тариалах	Д.Ууганбаяр	2013.04.11	14000000	4653693.72
39	эмийн сан	Д.Сувданчимэг	2013.04.16	3000000	0
40	худалдаа	Т.Болормаа	2013.04.12	5000000	189058.55
41	мал	Ц.Оюунболд	2013.05.01	2500000	8197.74
42	гутал	Ц.Лхам-Янжин	2013.05.01	1800000	0
43	утас засвар	Н.Мөнхбаяр	2013.05.03	500000	0
44	мал	Д.Отгонбаяр	2013.05.14	2000000	0
45	тариа	Л.Энхбат	2013.05.14	3500000	0
46	мал	Б.Дэлгэрдорж	2013.05.14	500000	0
47	мал	Ц.Баянжаргал	2013.05.14	1000000	0
48	сүүний үнээ	П.Батбаатар	2013.06.06	9000000	353624.3405
49	сүүний үнээ	Д.Сайнбилэг	2013.06.07	3000000	2155775.116
50	ноос ноолууран эдэлэл	Г.Өсөхбаяр	2013.06.07	2500000	236.83
51	гахай	Э.Жаргалсайхан	2013.06.06	2000000	42558.79
52	гахай	С.Отгонбаяр	2013.06.06	2000000	236.15
53	гахай	Г.Оюунцэцэг	2013.06.14	3000000	794389.63
54	чацаргана	Г.Ганзориг	2013.06.15	1500000	0
55	гахай	Ц.Ганбаатар	2013.06.07	1000000	4702.03
56	сүүний үнээ	Д.Ганболд	2013.06.06	3000000	27.76
57	дээл хийх	Б.Одонтуяа	2013.09.10	800000	18554.49
58	Оёдол	Б.Батцэцэг	2013.09.10	2000000	3701.87
59	блок үйлдвэрлэл	С.Отгонсүрэн	2013.09.10	2000000	9173.13
60	блок үйлдвэрлэл	Л.Сайнбилэг	2013.09.10	1800000	11895.09
61	тэжээлийн цех	Л.Мөнхбаяр	2013.09.10	15000000	-0.43
62	авто засвар	Д.Батболд	2013.09.10	10000000	0.46
63	сүүний үнээ	Г.Даваасүрэн	2013.09.10	3000000	340031.55
		2013 он дүн		137400000	19374241.86
64	тахианы аа	А.Цолмон 1.15	2014.04.09	2000000	0.00205
65	сүүний үнээ	Г.Бат-Эрдэнэ 4.08	2014.04.09	8000000	147211.5787
66	Оёдол	П.Отгон-Эрдэнэ 4.9	2014.01.16	4000000	4247686.512
67	Оёдол	Р.Баасансүрэн 5.12	2014.05.13	3000000	688391.7905
68	төмс хүнсний ногоо	П.Энхбаатар 6.16	2014.06.17	800000	864252.2914
69	хүлэмжийн ногоо	Х.Отгон 6.16	2014.06.17	3000000	2077254.675
70	гутал	Ц.Лхам-Янжин 6.26	2014.06.27	1500000	40932.7627
71	цагаан идээний цех	Х.Сэндмаа 11.25	2014.11.26	3500000	150092.331
		2014 оны дүн		25800000	8215821.943
72	суран эдэлэл	В.Мандахбаяр	2015.01.30	3000000	1053514.226
73	цайны газар	Б.Ганбат	2015.02.02	5000000	5064193.153
74	нөхөн сэргээх эмчилгээ	А.Эрдэнэчимэг	2015.02.02	5000000	5360947.779
75	хөрөө рам	О.Анхбаяр	2015.05.04	10000000	6397364.523
76	зегий	Б.Отгондорж	2015.05.22	5000000	4999006.709
77	хөрөө рам	Ж.Даваадорж	2015.07.16	9000000	7767295.856
78	зегий	Ж.Жамбалсүрэн	2015.05.28	3500000	2031123.46
79	төмс хүнсний ногоо	Г.Мятав	2015.05.21	2500000	-7357.1075

80	ногоо даршлах	Б.Должинсүрэн	2015.09.23	1000000	1003883.735
81	хурган дээл	Д.Цогт-Очир	2015.09.23	2000000	2133731.944
82	тахиааны аа	П.Мягмарсүрэн	2015.09.23	1000000	976144.5451
		2015 он дүн		47000000	36779848.82
83	үсчин	Нарангэрэл	2016.09.23	500000	3844.40385
84	мал эмнэлэг	данзан		14200000	14666853.01
85	талх нарийн боов	Чанцалдулам		8500000	8150965.001
86	талх нарийн боов	энхтөр		7000000	2070099.69
87	талх нарийн боов	даваадолгор		4000000	3580488.625
88	Алтан тахиа	Ж.Долгормаа		4000000	4121128.375
89	мал эмнэлэг	Н.Ганболд	2016.07.19	5000000	3353341.467
90	шатхуун ТС	М.Даваабаатар	2016.12.23	18500000	18777500
91	монгол гутал	Б.Магсаржалам	2016.12.23	5000000	4462500
92	Оёдол	Б.Пүрэвдолгор	2016.12.23	1000000	757500
93	хивс цэвэрлэгээ	П.Батцэнгэл	2016.12.23	1500000	1310250
		2016 он		69200000	61254470.57
		НИЙТ ДҮН		354140000	145135964.2
94	Оёдол	Ш.Эрдэнэчимэг	2017.05.02	3250000	3265708.333
95	хүнсний ногоо	М.Эрдэнэцогт	2017.05.02	3000000	3014500
96	үсчин гоо сайхан	Г.Мөнхзул	2017.05.02	4650000	4672475
97	хүнсний ногоо	мятав	2017.05.02	2200000	2210633.333
98	зайрмаг	Б.Мөнхбат	2017.05.02	4000000	4019333.333
99	зөгийн аа	батцэцэг	2017.05.08	4000000	4017333.333
100	нэхий элдүүр	ганхуяг	2017.05.10	9300000	9338750
101	хүнсний ногоо	баяжих	2017.05.19	5000000	5017083.333
102	хүнсний ногоо	л.сайнбилэг	2017.05.19	850000	852904.1667
103	хүнсний ногоо	д.төмөхбуд	2017.05.19	4000000	4013666.667
104	гутал	п.ууганбаяр	2017.04.07	5000000	5034583.333
105	хоол	ж.цэнджаргал	2017.04.07	3000000	2998250
106	хүнсний ногоо	б.шүхэртмаа	2017.04.27	6000000	6031500
107	суран эдлэл	Ш.Ганбат	2017.09.05	1000000	1000000
108	зөгий	батцэцэг	2017.09.05	2300000	2300000
109	Шилмэл сүрэг	Д.Амарбат	2017-09.07	5000000	5000000
		2017 он		62550000	62786720.83
		НИЙТ ДҮН		416690000	207922685.1

5.10 Байгал хамгаалах сан

Эхний үлдэгдэл		24086040
орлого	нөхөн сэргээлт орлого	10737625
	талбай тусгаарлалт	1260625
	хуудасны үнэ	310600
	Орлогын дүн	12308850
Зарлагын дүн	Тендэр	23164900
	хяналт шалгалт	1953780
	үнэт цаас	255000
	талбай тусгаарлалт	3450000
	бусад	1167046
	Зарлагын дүн	29990726
Эцсийн үлдэгдэл		6404164

Сумын Засаг даргын 2016 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн А/45 дугаартай захирамжаар “Ногоон бүл” бүлэгт “Цэцэрлэгт хүрээлэн тохижуулах, шар хуйс тарих төсөл”-д 10000.0 мянган төгрөгт багтаан хэрэгжүүлэх шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн

байна. Энэ төслөөс Маргад Орхон ХХК-д 1630 ширхэг мод бутыг нэг бүрийг 2500 төгрөгөөр нийт 4075.0 мянган төгрөг зарцуулсан, төсөлд ажилласан 9 хүнд /сургуулийн ажиллагсадад/ нийт 1223.0 мянган төгрөгийн ажлын хөлсийг 122.3 мянган төгрөгийн татвар суутган олгосон, 4500.1 мянган төгрөгийн материал, зарцуулсан байна. Дээрх 9 хүнд 7-р сард сургуулиас цалин олгоогүй байна.

Сумын Засаг даргын 2016 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн А/66 дугаартай захирамжаар “Цомхон бүл” бүлэгт /Ц.Ганхуяг/ “Цэцэрлэгт хүрээлэнг хашаажуулах, тохижуулах төсөл”-д 9692.1 мянган төгрөгт багтаан хэрэгжүүлэх шийдвэрийн дагуу хэрэгжүүлсэн байна. Энэ төслөөс 6784470 төгрөг материал худалдан авах урьдчилгаанд Ц.Ганхуягийн дансанд, 8-р сарын 11-д 1293867 төгрөгийг Ц.Ганхуягийн дансанд, 143763 төгрөгийг татварт шилжүүлсэн, 1432.4 мянган төгрөгийг цалинд олгосон байна. 2016 оны 07-р сарын 07-ны өдөр Б.Бямбажав ахлагчтай ажлын хэсэг хүлээж авсан акт үйлдсэн байна. Шинээр 132 м хашаа, хуучин 116 м хашааг зөөвөрлөж нийт 248м хашаа барьсан байна.

Сумын Засаг даргын 2016 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/110 дугаартай захирамжаар Д.Батцэнгэлтэй 3500.0 мянган төгрөгөөр зөөврийн компьютер 1ш, принтер 1ш, хогны машины дугуй 4ш-ийг худалдан авах гэрээ байгуулсан. 2016 оны 12 дугаар сарын 26-ны өдөр Тамгын даргаар ахлуулсан ажлын хэсэг хүлээж аван ЗДТГ-ын данс бүртгэлд тусгасан байна.

Шалгалтын үед утасаар /2017 оны ОНХС-ийн хөрөнгөөр сургуулийн заалны дээвэр солих ажилд зарцуулсан хөрөнгө/ мэдээлснийг шалгахад Хүрэмт багийн эрэмблэгдсэн ажлын эхний санал авсан “Заалны дээвэр солих” ажлыг “Бүтээлч бүл” бүлэг хийж гүйцэтгэсэн байна. 2017 оны 06 дугаар сарын 14-д Агтуу хайрхан ХХК-д материалын урьдчилгаанд 5000.0 мянган төгрөг, НИК-д шатахууны үнэнд 500.0 мянган төгрөг, Балигийн эх-д банз, палкны үнэнд 1000.0 мянган төгрөг, бүлгийн ахлагч Г.Пүрэвсүрэнд 500.0 мянган төгрөг, 7-р сарын 04-д бүлгийн ахлагч Г.Пүрэвсүрэнд санхүүжилтын үлдэгдэл 2650.0 мянган төгрөг, татварт 350.0 мянган төгрөгийг шилжүүлсэн байна. 2017 оны 06-р сарын 23-д Засаг даргын А/75 дугаар захирамжаар томилогдсон комисс тэмдэглэл хөтлөн хүлээж авсан байна.

5.11 Баянагт хөгжил сан:

Үзүүлэлт	Орлого	Зарлага
эхний үлдэгдэл	7338279	
Зээлийн эргэн төлөлт	33724772	
Зээлийн хүүгийн орлого	4875250	
иргэдээс хандив	3861650	
Трактор, машины үйлчилгээний орлого	1534500	
андуурсан	434000	
БХС-аас шатахуун	244500	
Газрын үнэ	250000	
Гүүрний хураамж	1340900	
Зээл олголт		38705500
буцалтгүй дэмжлэг		350000
наадмын талбай барих төсөлд		3402000
андуурсан		882000
ухдаг тракторын сэлбэг		1168145
шовгорын мөнгөний буцаалт		125000
Томилолт бичиг хэрэг		381000
хэвлэл мэдээлэл		4858000

шатахууны зардал		592530
банкны хураамж		37179.87
данс хооронд	3276747	3276747
дүн	49542319	53778101
Эцсийн үлдэгдэл		3102596.62

Орон нутгийн хөгжлийн сангийн 2016 оны 2 ажил , 2017 оны 1 ажил, Байгал хамгаалах сангийн 1 ажил дээр иргэдээс мэдээлэл ирсэнийг мэдээллийн дагуу баримтаар шалгахад зөрчил илэрсэнгүй. Мэдээллийн хариуг тухай бүрд нь утасаар өгөв.

6.Илэрсэн зөрчил

1. Засаг даргын Тамгын газар 2016 оны 03 дугаар сарын 23-ны өдөр 14 дугаартай бэлэн мөнгөний хүсэлтээр 3-р сарын цалинг Төрийн банкинд дахь 120100061680 дугаартай дансанд 10938318 төгрөг шилжүүлэхдээ цалингийн тооцооны хүснэгтээс 1136663 төгрөгийг илүү шилжүүлсэн байна. Илүү шилжүүлсэн 1136663 төгрөгийг нярав Д.Ганзоригт бэлнээр олгосон ба Д.Ганзориг НДС-ийн төрийн банкинд дахь 120100040815 дугаартай дансанд бэлнээр тушаасан байна.

2. 2016 оны 3-р сарын 31-ний өдрийн 28 дугаар төлбөрийн хүсэлтээр ХААН банкны 5271122387 дугаартай дансанд Б.Отгонцэцэгийн томилолтын зардлыг 1 хоногоор илүү тооцон 86000 төгрөг шилжүүлсэн байна. аймагт 14000 төгрөг/

3. Аймгийн Засаг даргын 2016 оны 02-р сарын А/52 дугаар захирамжаар Засаг дарга, Тамгын газрын дарга, БОХ-ын улсын байцаагч нарт 1 сарын цалингийн шагнал олгохдоо ХХОАТ-ын хөнгөлөлт эдлүүлэн 21.0 мянган төгрөг илүү олгосон

4. 2016 оны 11 дүгээр сарын 15-ны 253 дугаар төлбөрийн хүсэлтээр ажилтнуудад томилолтын зардалд 753500 төгрөг олгохдоо газрын даамал Б.Эрдэнэчимэгт аймагт 2016 оны 4-р сарын 25-аас 4 хоног ажиллах үеийн томилолтын зардлыг 35500 төгрөгөөр тооцон 142.0 мянган төгрөг олгож 26.0 мянган төгрөг илүү олгосон

5. 2016 оны 11-р сарын 24-ний өдрийн 263 дугаар төлбөрийн хүсэлтээр 11-р сарын цалинг төрийн банкинд 9044200 төгрөг шилжүүлсэн байна. Цалингийн тооцооны хүснэгтээр Засаг дарга Ж.Ганболдод 3 хоногийн 144904 төгрөгийн цалин илүү, Тамгын газрын дарга Д.Нармандахад 12 хоногийн 358551 төгрөгийн цалинг тус тус ажилласан хоногийг харгалзалгүй нийт 503455 төгрөг илүү олгосон байна. Илүү олгосон цалингаас 2016 оны 12-р сарын 21-д Тамгын газрын дансанд нягтлан бодогч Отгонцэцэг 118000 төгрөг, 12-р сарын 22-д Нармандах 296100 төгрөг тушаасан байна. Илүү бодогдсон цалингаас дутуу тушаагдсан 89355 төгрөгийг данс бүртгэлд тусгаагүй байна.

6. 2016 оны 12-р сарын цалин бодохдоо С.Эрдэнэчимэгийн цалинг 25 хоногоор тооцон 553313 төгрөгийг олгож 88530 төгрөгийг илүү олгосныг 12-р сарын 21-д 71710 төгрөг буцааж тушаан 16820 төгрөг дутуу тооцон данс бүртгэлд тусгаагүй байна.

7. 2016 оны 12-р сарын 23-ны өдөр 160 дугаартай бэлэн мөнгөний хүсэлтээр Тамгын газрын 2016 оны 12-р сарын 24-ний өдрийн Б/32 дугаар тушаалаар 16 ажилтанд 10-30 хувийн үр дүнгийн урамшуулал олгохдоо Тамгын газрын даргад 10 хувь буюу 62747 төгрөгийн урамшуулал олгосон байна.

8. 2016 оны 03-р сарын 14-ний өдрийн 4 дугаартай бэлэн мөнгөний хүсэлтээр багийн дарга Т.Пүрэвсанаагийн амралтын мөнгийг 556627 төгрөгөөр тооцон 27738 төгрөг дутуу бодож олгосон байна.

9. Багийн дарга нарын 7-р сарын цалинг ажлын цагийн тооцоонд ажилласан цагийг бодоогүй байхад бодож олгосон байна.

10. Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн материалд аж ахуйн материалын шинжтэй материал бүртгэсэн, шаардах хуудас дугааргүй, бичгийн цаасыг боодлоор орлогод авч ширхэгээр зарцуулсан, жолоочийн тооцооны хуудсыг хагас дутуу хөтөлсөн, замын хуудас дутуу, тооцоо бодсон, бодуулсан жолоочийн гарын үсэггүй, няравын гаргасан тайланд нягтлан бодогчийн гарын үсэггүй, түлшний мод хүлээн авахдаа акт үйлдээгүй, зарлага гаргахдаа бөөн дүнгээр сар улирлаар зарцуулсан, Засаг даргын нөөц сангаас Тамгын газрын машины дугуй авсан

11. Засаг даргын Тамгын газрын бичээч, үйлчлэгч нарт ур чадварын нэмэгдлийг тогтмол нэмэгдэл мэтээр олгох шийдвэр гаргасны дагуу олгосон.

12. БХС-ийн хөрөнгөөр бэлтгэсэн 110.0 мянган төгрөгийн принтерийг данс бүртгэлд тусгаагүй

13. Тусгай зориулалтын сангуудаас хувь хүний харилцах дансанд орсон мөнгөнд бэлэн мөнгөний гүйлгээний тайлан гаргаагүй.

14. Баян агт хөгжил сан, ГХС нь арилжааны банкинд данстай байна

7. Дүгнэлт

Орон нутгийн хөгжлийн сан, СХСан, БХСан, ЖДҮДСан зэрэг тусгай зориулалтын сангуудад зөрчил гараагүй, төлөвлөлт хуулийн дагуу хийгдсэн баримт боловсруулалт, тайлагналт, 2016 оны төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийг ИТХ-аар батлуулсан нь төсвийн тухай хуулийн хэрэгжилт сайн байна. Мөн Тендерийн бичиг баримттай танилцахад Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу хийгдсэн байна.

БХС-ийн хөрөнгөөр Ногоон байгууламж, Шандны хамгаалалт хашаа, Байгаль орчины мэдээлэл, сургалт сурталчилгааны тоног төхөөрөмж гэсэн 3 ажлыг хуулийн дагуу зохион байгуулсан байна.

Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар 2016-2020 онд тэргүүлэх чиглэл батлагдсан тогтоолын дагуу Орон нутгийн хөгжлийн сангаас иргэдийн саналын тоогоор эрэмбэлэгдсэн ажил үйлчилгээг санхүүжүүлсэн байна.

СХСан болон ЖДҮДСангийн үлдэгдэл зээлийн авлага нь аудитлагдсан санхүүгийн тайлантай тохирч байна. СХСангаас урсгал зардал /Сургалт сурталчилгаа болон хяналт шалгалтын / гаргаагүй байна.

АШБ болон НББ-ийн хөтлөлт тайлан тэнцэл гаргалт нь хуулийн хугацаанд тайлан тэнцлийг гарган аудитын байгууллагаар баталгаажуулан НББын тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу үнэн зөв бодитой илэрхийлэгдсэн ч байгууллагын дотоод хяналт хэрэгжүүлээгүйгээс зөрчил дутагдал илрэх шалтгаан болсон байна.

8. Авсан арга хэмжээ

Илэрсэн зөрчилтэй холбогдуулан 367660 төгрөгийн төлбөрийн акт тогтоож, улсын байцаагчийн албан шаардлага хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өглөө.

9.Цаашид авах арга хэмжээ, шийдвэрлэвэл зохих асуудал

1. Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ыг мөрдөж ажиллах, жилийн эцсийн санхүүгийн тайлан тэнцэлд зардлын бүлэг болон эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан тухай тайлангийн тодруулгад дэлгэрэнгүй тусгаж байх.

2. Сэлбэг, шатахууны зардлын гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, автомашины хувийн хэрэг хөтлөх, жолооч бүрээр шатахууны тоцоог бодож хэвших, автомашины шатахууны 100 км-т зарцуулах нормыг тооцохдоо Дэд бүтцийн сайдын 2004 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 19 дүгээр тушаалаар баталсан “Автомашины 100 км гүйлтэд зарцуулах шатахууны зарцуулалтын жишиг норм”, “Автомашины шатахуун зарцуулалтын нормыг тооцох заавар”-ыг мөрдөж ажиллах.

3. Анхан шатны баримтын бүрдлийг тухай бүр хангаж, бараа материал, бэлэн мөнгөний гүйлгээний тайланг сар бүр, үндсэн хөрөнгийн тайланг хагас бүтэн жилээр гаргаж, Монгол Улсын Сангийн сайдын 2000 оны 69 тоот тушаалаар баталсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийг мөрдөж ажиллах.

4. Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын дагуу бэлэн мөнгөний гүйлгээний тайланг сар бүр гаргах

5. Шилэн дансны тухай хууль, журам, захирамж, шийдвэрүүдийг хэрэгжүүлж биелэлтийг тооцож, хариуг улирал тутам бичгээр ирүүлэх./Аймгийн ИТХТ-ийн тогтоол, Засаг даргын албан даалгавар, Засаг даргын захирамж /

6. Ур чадварын нэмэгдлийг олговол зохих ажилтнуудад ажил дүгнэх журам боловсруулан батлуулж, олгож байх

7. Төлбөрийн 229922 төгрөгийг 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Төрийн сангийн хүү торгуулийн орлогын 100040000952 тоот дансанд төвлөрүүлэхийг ИТХ-ын дарга С.Ганбат , Засаг дарга Ж.Ганболд, Тамгын газрын дарга Д.Нармандах , Санхүүгийн албаны дарга П.Мягмарсүрэн, нягтлан бодогч Б.Отгонцэцэг нарт хариуцуулав.

8. Илэрсэн зөрчлүүдийг таслан зогсоож, шалгалтын мөрөөр тодорхой ажил зохион байгуулан улсын ахлах байцаагчийн өгсөн албан шаардлагын биелэлтийг бүрэн хангуулж, 2017 оны 12 дугаар сарын 15-ны дотор аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албанд албан бичгээр болон sankhuu_audit_bu@yahoo.com хаягаар хариу ирүүлэх

БИЧСЭН: САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УЛСЫН АХЛАХ
БАЙЦААГЧ Д.САРАНГЭРЭЛ

